

**ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ГААЛИЙН ГАЗРЫН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН  
Э.ДОЛГОРЖАВ МИНИЙ 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		
		Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт
1	2	3	4	5
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжинэ.</b>				
<b>Зорилт 4. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх</b>				
1.	Арга хэмжээ №7 Газрын даргын гаргасан тушаалын хэрэгжилт, тушаалыг байдал	Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээгээр 85 ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байх.	Хянуулсан тушаалууд алдаа дутагдалгүй байх.	<p>Газрын даргын 75 тушаал гарснаас А индексийн 27, Б индексийн 48-н тушаал, нийт 155 тушаалын хэрэгжилтийг хангулсан ба захиргааны хувийн хэрэг хөтлөх журмын дагуу 75 оролцогчдод танилцуулах хуудсанд давхардсан тоогоор 300 орчим албан хаагчаар гарын үсэг зуруулсан, 15 орчим албан хаагчид мэдэгдэх хуудас үйлдэж, 2 сонсгох ажиллагааны тэмдэглэл болон нотлох баримтыг бүрдүүлж хувийн хэрэг үүсгэсэн.</p> <p>Гаалийн ерөнхий газрын даргын 2020 оны А/218 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Захиргааны хувийн хэрэг хөтлөх журам” -ын 2022 оны бүтэн жилийн хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 4 зүйл, 5 хавсралтад холбогдох хэрэгжилтийг ГЕГ-ийн Хуулийн хэлтэст цахимаар болон цаасаар хүргүүлсэн.</p>
2.	Арга хэмжээ №9. Албан хаагчдын ажиллах, амьдрах орчныг сайжруулах, Хүний нөөцийн судалгаа хийж ашигласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Судалгаа үнэн бодитой хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.	<p>Засгийн газрын 1997 оны 153 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/659 тоот албан бичгээр 44 албан хаагчид нэмэгдэл олгуулах саналыг заасан хугацаанд хүргүүлж, ГЕГ-ийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 5/10 дугаар тушаалаар баталгаажиж ирсэн.</p> <p>Албан хаагчдийн орон байр, зээлийн судалгааг 221 албан хаагчдаас 2 удаа шүүж, эрэмбэлэн нэгтгэж, 34 албан хаагчийн жагсаалт бүхий файлыг Хүний нөөцийн хэлтэст 2024.01.04-ны өдөр заасан хугацаанд 99072807 вайбэраар хүргүүлсэн.</p> <p>Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын байцаагчийн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын ажилласан жил, утасны дугаарын судалгааг гаргаж Захиргааны удирдлагын газрын гаалийн улсын байцаагч Б.Нанзадхоролд заасан хугацаанд 2024.01.26-ны өдөр 88104562 вайбэраар хүргүүлсэн.</p>

			<p>Ахлахуудын ерөнхий болон тусгай шалгалт өгсөн эсэх судалгааг гаргаж ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын байцаагч Итэшмаад заасан хугацаанд 2024.02.01-ний өдөр Спаркаар хүргүүлсэн.</p> <p>Сар бүрийн 05-ны дотор албан хаагчдын ажилласан цагийн тооцоог 6 удаа <a href="https://cerp.ecustoms.mn/">https://cerp.ecustoms.mn/</a> дотоод системд ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн мэдээ мэдээлэл хэсэгт заасан хугацаанд байршуулсан.</p> <p>Дотоод хяналт аюулгүй байдлын хэлтэст газрын даргын шийдвэрээр сахилгын шийтгэл авсан албан хаагчдын судалгаа, албан хаагчдын ажилласан цагийн тооцоог нотлох баримтын хамт 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар гаргаж 2024.06.06-ны өдөр 01/639 тоот албан бичгээр заасан хугацаанд хариуг хүргүүлсэн.</p> <p>Албан хаагчдын цалин хөлс, нэмэгдлийн төсвийн төсөөллийн 222 албан хаагчийн судалгааг 2025.12.31-ны өдрийн байдлаар гаргаж Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын байцаагч Б.Батчимэгт заасан хугацаанд 99072807 вайбэраар 2024.06.13-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>Төрийн албаны богино болон дунд хугацааны, мэргэшүүлэх бусад сургалтад хамрагдсан албан хаагчид, Сахилгын шийтгэлтэй албан хаагчидын 2024 оны 06 сарын 24-ний өдрийн байдлаарх судалгааг тус тус гаргаж 2024.06.24-ний өдөр Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын байцаагч Б.Итэшмаад спаркаар заасан хугацаанд хүргүүлсэн.</p> <p>Зуны ажлын хувцас /Хүрэм, өмд, малгай/ 5.11/-ны хангалтын олгохтой холбоотойгоор 2020 оны 08 дугаар сараас хойш шинээр томилогдсон 94 гаалийн улсын байцаагчийн судалгааг гаргаж 2024.06.05-ны өдөр Санхүү, хөрөнгө оруулалтын газарт заасан хугацаанд хүргүүлсэн.</p> <p>Санхүү хөрөнгө оруулалтын газарт 2024.02.28-ны өдөр 199 албан хаагчийн судалгааг тулгалт хийж, нэгтгэж заасан хугацаанд хүргүүлсэн.</p> <p>Чингис хаан олон улсын нисэх буудал гаалийн газрын Хятад хэл сурах тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах албан хаагчдын нэрсийг Хүний нөөцийн хэлтэст 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр буюу заасан хугацаанд хүргүүлсэн.</p> <p>Хүний нөөцийн хэлтэст олон жил үр бүтээлтэй ажиллаж төрийн дээд одон медаль, Засгийн газрын болон байгууллагын шагналаар шагнуулах 25 албан хаагчийн саналыг 2024 оны 05 сарын 15-ны өдрийн 01/321 тоот албан бичгээр заасан хугацаанд хүргүүлсэн.</p> <p>Гаалийн тухай хуулийн 280 дугаар зүйлийн 280.7-д заасны дагуу 2024 онд болзол, шаардлага хангасан тав болон түүнээс дээш жил ажилласан, гаалийн улсын байцаагчид таван жил тутам сүүлийн 12 сарын албан тушаалын үндсэн цалингийн хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгуулахаар холбогдох матриалыг Хүний нөөцийн хэлтэст 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/191 тоот албан бичгээр 107 албан хаагчид олгуулах санал хүргүүлснээс хагас жилийн байдлаар 102 албан хаагчид олгогдсон байна.</p>
--	--	--	--

3.	Арга хэмжээ №11. Албан хаагчдын хувийн хэргийн баяжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Холбогдох журмын дагуу	<p>1. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүрдүүлэх журам"-ын дагуу нийт 234 албан хаагчаас шинэчлэгдсэн анкетыг баталгаажуулан авч ГЕГ-ийн Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн, Мөн ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсээс ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлтыг нийт албан хаагчдаас гаргуулан авч цаасаар хүлээлгэн өгсөн. Хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлж, баяжилтийг тухай бүр хийсэн.</p> <p>2. Төрийн албан хаагчийн шинэчлэгдсэн анкетын дагуу Хүний нөөцийн <a href="https://hrm.csc.gov.mn/hrsuite">https://hrm.csc.gov.mn/hrsuite</a> цахим системд 187 албан хаагчын хувийн мэдээллүүдийг шинэчлэн оруулсан ба 117 албан хаагчын ажил эрхлэлтийн түүхийг нотлох баримттай тулгаж, файлаар хавсаргасан.</p> <p>3. Байгууллагын албан хаагчдын хувийн хэргийг бүтцийн нэгж, албан тушаалын ангилал, дараалалд оруулан цэгцэлж, цоожтой, битүү зориулалтын шүүгээнд байршуулан, нууцлалыг хамгаалсан байна.</p>
4.	Арга хэмжээ №12. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		<p>Тус газарт 2024 оны 06 сарын 25-ны өдрийн байдлаар Гаалийн ерөнхий газрын даргын 73 тушаалаас А индексийн 4, Б индексийн 69 тушаалыг тус тус бүртгэж, судалгааг үүсгэсэн байна.</p> <p>Гаалийн ерөнхий газрын даргын тушаалыг давхардсан тоогоор 1000 орчим албан хаагчид тухай бүр мэдэгдэх хуудсанд гарын үсэг зуруулж, утсаар холбогдох, мэйл хаягаар илгээх болон вайбэраар илгээн танилцуулж хэрэгжилтийг хангулсан.</p> <p>Нийт томилогдон ирсэн 35 албан хаагчийг ажлын байрандээр тушаалын дагуу ажиллуулахад хяналт тавьж ажилласан.</p> <p>Тус газарт 2024 оны 06 сарын 25-ны өдрийн байдлаар Гаалийн ерөнхий газрын даргын 73 тушаалаас Б индексийн 69, А индексийн 4 тушаалыг тус тус бүртгэж, судалгааг үүсгэсэн байна.</p> <p>Гаалийн ерөнхий газрын даргын тушаалыг тухай бүр биеэр, утсаар холбогдох, мэйл хаягаар илгээх болон вайбэраар илгээн танилцуулж, газрын даргын тушаалыг ГЕГ-ын даргын 2020 оны А/218 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам"-д заасны дагуу тушаал бүрт "Оролцогчид шийдвэрийн төсөл танилцуулах хуудас" болон "Захиргааны гэрээний хяналтын дагалдах хуудас" ашиглан биеэр болон утсаар танилцуулж хэрэгжилтийг хангулсан.</p> <p>Гаалийн ерөнхий газрын даргын тушаал 2023 оны эхний хагас жилээр нийт 80 буюу 13 А тушаал, 67 Б тушаал, 2024 оны эхний хагас жилээр нийт 73 буюу 4 А тушаал, 69 Б тушаал гарсан байна. Гаалийн ерөнхий газрын даргын 2020 оны А/218 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Захиргааны хувийн хэрэг хөтлөх журам" -ын хавсралтаар батлагдсан загварыг тушаалын хэрэгжилтийг хангуулахад ашигласан ба 2024 оны А/190 дүгээр тушаалын 2.6 дугаар хавсралтад зааснаар тушаалын хэрэгжилтийг өмнөх жилийнхтэй харьцуулахад 100 хувь хангуулж ажилласан ба тушаалын шийдвэртэй</p>

				холбоотой нийтийн болон бусдын эрх ашиг сонирхол зөрчигдсөн гомдол мэдээлэлгүй ажилласан.
--	--	--	--	---

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ



Э.ДОЛГОРЖАВ

2024.06.09

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
дэргүүн 2023 оны 98 дугаар тушаалын  
8 дугаар хавсралт

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЭРДЭНЭБАТЫН ДОЛГОРЖАВЫН  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,  
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

**Байгууллагын нэр:** Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар

**Нэгжийн нэр:** Захиргааны алба

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд егсэн онoo	Төлөвлөсөн хугацаанд		Нийлбэр онoo	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дэхин үнэлгээн онoo		
			гүйцэтгэсэн байдал					
			1	2				
		Оноо	60	10	70	5		
		хүртэл	хүртэл	хүртэл	хүртэл			

**Зорилт 1. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн  
арга хэмжээний биелэлт**

1.1	Тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал	53	10	63	
1.2	Хүний нөөцийн судалгааг хийж ашигласан байдал	51	9	60	
1.3	ТЖАХ-ийн сахилга, ёс зүй	56	10	66	

**Зорилт 2. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтыг  
хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт**

2.1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, тайлагнах	55	10	65	
2.2	Төрийн албаны тухай, Нийтийн албананд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллах	53	8	61	
2.3	Архив, албан хэрэг хөтөллтийг зохих заавар, журам, стандартад нийцсэн баримт бичиг боловсруулах хэрэгжилтийг ханган ажиллах	54	9	63	
2.4	Гаалийн удирдах төв байгууллагын холбогдох нэгжээс ирүүлсэн зөвлөмж, үүрэг, даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах	53.8	10	63.8	
2.5	Гаалийн өрөнхий газар болон бусад холбогдох байгуулагаас зохион байгуулсан хурал, сургалт, олон нийтийг хамруулсан арга хэмжээнд оролцох	53	10	63	

**Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт**

1	Удирдлагаас егсэн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох	54	9	63	
---	--	----	---	----	--

**Үнэлгээ өгсөн: Нээжийн дарга**

Захиргааны албаны дарга  
(албан тушаал)

(гарын үсэг)

С.Батдамба  
(овог, нэр)

2024.06.19.

(огноо)

**Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:**

Гаалийн улсын байцаагч  
(албан тушаал)

**Төрийн жинхэнэ албан хаагч:**

(гарын үсэг)

Э.Долгоржав  
(овог, нэр)

2024.06.20.

(огноо)

**Үнэлгээг хянасан:****Үнэлгээний багийг төлөөлж ахлаач:**

Хөрио цээрийн албаны дарга  
(албан тушаал)

(гарын үсэг)

Б.Отгонцэцэг  
(овог, нэр)

2024.06.20.

(огноо)

**Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:**

Захиргаа, хүний нөөц хариуцсан  
гаалийн улсын ахлах байцаагч  
(албан тушаал)

(гарын үсэг)

Д.Хонгорзул  
(овог, нэр)

2024.06.20.

(огноо)

**Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч**

Газрын дарга  
(албан тушаал)

(гарын үсэг)

Г.Баасандорж  
(овог, нэр)

2024.06.20.

(огноо)